2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,951,864,434.88	1,916,341,693.14	1,547,585,798.46	5,415,791,926.48
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	7,466,000.00	0.00	0.00	7,466,000.00
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
7	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
8	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	53,500,383.14	53,500,383.14
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,959,330,434.88	1,916,341,693.14	1,601,086,181.60	5,476,758,309.62
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,959,330,434.88	1,916,341,693.14	1,601,086,181.60	5,476,758,309.62
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,959,330,434.88	1,916,341,693.14	1,601,086,181.60	5,476,758,309.62
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
17	Өмчид гарсан өөрчлөлт	523,795,393.85	302,088,176.16	-19,905,409.88	805,978,160.13
18	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	2,247,063,971.08	2,247,063,971.08
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	2,483,125,828.73	2,218,429,869.30	3,828,244,742.80	8,529,800,440.83




2.5. АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,964,121,900.00</b>	<b>2,757,845,299.86</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,775,334,300.00</b>	<b>2,690,137,699.86</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,725,079,400.00</b>	<b>2,639,956,899.86</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,831,707,300.00</b>	<b>1,801,515,521.32</b>
210101	Үндсэн цалин	1,413,203,600.00	1,393,201,756.82
210102	Нэмэгдэл	224,910,000.00	232,547,224.80
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,240,000.00	6,344,994.90
210104	Урамшуулал	135,960,700.00	123,152,877.90
210105	Гэрээт ажлын хөлс	48,393,000.00	46,268,666.90
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>247,280,700.00</b>	<b>229,142,505.94</b>
210201	Тэтгэврийн даатгал	174,012,200.00	162,110,138.54
210202	Тэтгэмжийн даатгал	18,317,100.00	17,665,676.89
210203	ҮОМШӨ-ний даатгал	14,653,600.00	13,419,738.46
210204	Ажилгүйдлийн даатгал	3,663,600.00	3,262,097.02
210205	Эрүүл мэндийн даатгал	36,634,200.00	32,684,855.03
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>344,007,700.00</b>	<b>340,329,562.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	17,765,600.00	16,988,217.00
210302	Түлш, халаалт	323,522,100.00	323,097,345.00
210303	Цэвэр, бохир ус	2,720,000.00	244,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>92,301,400.00</b>	<b>91,198,979.00</b>
210401	Бичиг хэрэг	6,396,200.00	6,390,170.00
210402	Тээвэр, шатахуун	46,417,400.00	45,915,460.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,246,300.00	5,007,229.00
210404	Ном, хэвлэл	1,124,200.00	885,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	8,317,300.00	8,706,170.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	24,800,000.00	24,294,950.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>109,923,500.00</b>	<b>89,259,335.60</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	33,183,900.00	33,152,155.00
210502	Хоол, хүнс	71,671,800.00	51,155,680.60
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,067,800.00	4,951,500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>49,988,000.00</b>	<b>43,939,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	20,416,700.00	20,416,700.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,233,300.00	2,233,300.00
210604	Урсгал засвар	27,338,000.00	21,289,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>8,090,100.00</b>	<b>6,736,500.00</b>
210702	Дотоод албан томилолт	8,090,100.00	6,736,500.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>10,804,600.00</b>	<b>9,682,386.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,243,400.00	2,775,800.00

УБС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
 20 ХЯЗГААРЛАЛТАН  
 САНАЛ ДҮГНЭЛТ

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,886,400.00	1,886,400.00
210803	Даатгалын үйлчилгээ	716,000.00	715,315.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	243,000.00	205,484.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	186,000.00	135,975.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,701,800.00	3,632,300.00
210807	Газрын төлбөр	828,000.00	331,112.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>30,976,100.00</b>	<b>28,153,110.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,964,800.00	20,626,710.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,011,300.00	7,526,400.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>50,254,900.00</b>	<b>50,180,800.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>50,254,900.00</b>	<b>50,180,800.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	46,990,400.00	46,923,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,264,500.00	3,257,500.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>108,787,600.00</b>	<b>67,707,600.00</b>
223001	Бусад хөрөнгө	108,787,600.00	67,707,600.00
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>80,000,000.00</b>	<b>0.00</b>
230001	Эргэж төлөгдөх зээл	80,000,000.00	0.00
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>2,964,121,900.00</b>	<b>2,901,715,911.73</b>
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,977,552,800.00</b>	<b>1,930,751,400.52</b>
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,886,053,100.00	1,839,251,733.52
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	91,499,700.00	91,499,667.00
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>844,934,700.00</b>	<b>829,613,183.21</b>
320001	Орон нутгийн төсвөөс	844,934,700.00	829,613,183.21
<b>33</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>41,708,700.00</b>	<b>38,018,828.00</b>
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	41,708,700.00	38,018,828.00
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>99,925,700.00</b>	<b>103,332,500.00</b>
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	45,550,000.00	103,332,500.00
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	54,375,700.00	0.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	62,752,233.88
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	206,622,845.75
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>1,055.00</b>	<b>1,055.00</b>
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>6.00</b>	<b>6.00</b>
610001	Төсвийн байгууллага	6.00	6.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>151.00</b>	<b>151.00</b>
620001	Удирдах ажилтан	12.00	12.00
620002	Гүйцэтгэх ажилтан	98.00	98.00
620003	Үйлчлэх ажилтан	32.00	32.00
620004	Гэрээт ажилтан	9.00	9.00



63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	747.00	747.00
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	577.00	577.00
630001	Төрийн өмчит ЕБС	577.00	577.00
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	170.00	170.00
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	170.00	170.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	151.00	151.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	11.00	11.00
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	63.00	63.00
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	4.00	4.00
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	24.00	24.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	36.00	36.00
650010	Гэрээт ажилтан	6.00	6.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	7.00	7.00



**2.6. АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН НЭМЭЛТ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

**/төгрөгөөр/**

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>152,429,206.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>150,929,206.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>99,655,206.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>22,185,414.00</b>
210101	Үндсэн цалин	16,819,970.00
210102	Нэмэгдэл	5,365,444.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>2,431,843.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	2,351,287.00
210202	Тэтгэмжийн даатгал	20,139.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	16,111.00
210204	Ажилгүйдлийн даатгал	4,027.00
210205	Эрүүл мэндийн даатгал	40,279.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>6,890,000.00</b>
210302	Түлш, халаалт	6,890,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>5,943,267.00</b>
210401	Бичиг хэрэг	366,847.00
210402	Тээвэр, шатахуун	4,148,220.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,055,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	372,900.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>47,553,193.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	46,512,193.00
210502	Хоол, хүнс	1,041,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>5,266,300.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,930,000.00
210604	Урсгал засвар	3,336,300.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>9,385,189.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,970,189.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,415,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>51,274,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>49,000,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	49,000,000.00
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>2,274,000.00</b>
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	2,274,000.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>1,500,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>1,500,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,500,000.00
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>153,177,536.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>153,177,536.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	2,160,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	200,000.00

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,687,247.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	142,130,289.00
<b>III</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	<b>748,330.00</b>
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	748,330.00

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баруунтуруун сумын Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Р.Аюуш гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Баруунтуруун сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 1/239 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Шалгагдагч этгээд, түүний орчин ба дотоод хяналт

Баруунтуруун сумын Засаг дарга нь “Төрийн захиргааны байгууллагын манлайллыг дээшлүүлэх, хууль тогтоомж, Засгийн газар болон Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх ажлыг шуурхай зохион байгуулах, хэрэгжүүлэх ажлыг шуурхай зохион байгуулах, хэрэгжилтийн явцад хяналт шинжилгээ хийх, үр дүнг үнэлж дүгнэх, удирдлагыг цаг үеэ олсон зөвлөгөө, бүх талын үйлчилгээ, мэдээллээр хангах, иргэдэд төрийн үйлчилгээг хөнгөн шуурхай хүргэх” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Нийгмийн хөгжлийн бодлого
- Эдийн засгийн хөгжлийн бодлого
- Байгаль орчин ногоон хөгжлийн бодлого
- Засаглалын бодлого зэрэг зорилтуудыг дэвшүүлэн ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Малын тоо толгойн албан татварын тухай хууль
- Нийгмийн даатгалын сангийн 2021 оны төсвийн тухай хууль
- Эрүүл мэндийн даатгалын сангийн 2021 оны төсвийн тухай хууль
- Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор “төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”

Шалгагдагч этгээдийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд

хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Сумын санхүүгийн нэгтгэсэн тайланд мөрдөх тусгайлан баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй бөгөөд Сангийн яамнаас гаргасан бодлого шийдвэрүүдийг хэрэгжүүлэн и-баланс цахим программ хангамж ашиглан холбогдох хууль тогтоомж, Нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцүүлэн, үйл ажиллагааны онцлогт тохируулан ашиглаж байна.

Баруунтуруун сумын Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баруунтуруун сумын Засаг даргын 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож 40.3 сая төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөхгүйгээр нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 4,031.9 сая төгрөгийн 1 хувь буюу 40.3 сая төгрөгөөс 80 хувиар тооцож 32.2 сая төгрөгөөр тогтоолоо. Материаллаг байдлыг шинж чанарын хувьд авч үзлээ.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Баруунтуруун сумын Засаг даргын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,052.9 сая төгрөгөөр буюу 55.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

		/сая.төгрөг/	
Мөнгөн хөрөнгө	<b>95.0</b>	230.9	135.8
Авлага	176.1	201.3	25.2
Урьдчилгаа	0.0	0.0	0.0
Бараа материал	221.2	335.6	114.3
Үндсэн хөрөнгө	4,985.1	7,762.6	2,777.5
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>5,477.4</b>	<b>8,530.4</b>	<b>3,052.9</b>
Нийт өр төлбөр	0.7	0.6	-0.1
Цэвэр хөрөнгө өмчийн дүн	5,476.7	8,529.8	3,053.0
Засгийн газрын хувь оролцоо	5,476.7	8,529.8	3,053.0
<b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>5,477.4</b>	<b>8,530.4</b>	<b>3,052.9</b>

Эх сурвалж: Баруунтуруун сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлан

**3.5.1 Мөнгөн хөрөнгө**

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 230.9 сая төгрөг болж 135.8 сая төгрөгөөр өссөн нь орон нутгийн ерөнхий орлого, Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сан, Эрүүл мэндийн төвийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Аудитын илрүүлэлт:

**Баруунтуруун сумын Засаг даргын тамгын газар:**

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасныг зөрчин 65.2 сая төгрөгийн дотоод томилолтын зардлыг шууд зардалд бүртгэсэн алдааг залруулга хийсэн.

**Баруунтуруун сумын Соёлын төв:**

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасныг зөрчин дотоод томилолт, нэг удаагийн тэтгэмж шагнал урамшууллын зардлыг шууд зардалд бүртгэсэн 31.5 сая төгрөгийн алдааг залрууллаа.

**Баруунтуруун сумын Ерөнхий боловсролын сургууль:**

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасныг зөрчин нийгмийн даатгалын шимтгэл, цалингийн урьдчилгаа, тогтмол зардал, дотоод томилолт, нэг удаагийн тэтгэмж шагнал урамшууллын зардлыг шууд зардалд бүртгэсэн 385.4 сая төгрөгийн алдааг залрууллаа.


**3.5.2 Авлага**

Авлага дансны үлдэгдэл 201.3 сая төгрөг болж 25.2 сая төгрөгөөр өссөн нь Сум хөгжүүлэх сан, Хүүхдийн цэцэрлэг, Ерөнхий боловсролын сургууль, Засаг даргын Тамгын газар, Эрүүл мэндийн төвийн авлага нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Аудитын илрүүлэлт:

**Баруунтуруун сумын Ерөнхий боловсролын сургууль:**

- Боловсрол, шинжлэх ухааны яамны "Боловсрол чанарын шинэчлэл" төслийн хүрээнд хийгдээгүй ажлын санхүүжилт 0.6 сая төгрөгийг нярвын дансанд шилжүүлснийг санхүүгийн тайланд авлага тусгуулж залруулсан.
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.3 дэх хэсэгт заасныг зөрчин цалингийн урьдчилгааг суутгаагүй 0.2 сая төгрөгийг авлагаар бүртгэлд тусгуулж залрууллаа.



### 3.5.3 Бараа материал

Бараа материалын дансны үлдэгдэл 335.6 сая төгрөг болж 114.3 сая төгрөгөөр өссөн нь Ерөнхий боловсролын сургууль, Эрүүл мэндийн төвийн бараа материал нэмэгдсэнээс шалтгаалжээ.

### 3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 7,762.6 сая төгрөг болж 2,777.5 сая төгрөгөөр өссөн нь Хүүхдийн цэцэрлэгийн шинэ барилга ашиглалтад орсон, Эрүүл мэндийн төвийн хөрөнгө нэмэгдсэнтэй холбоотой байна.

### 3.5.5 Өр төлбөр

Өр төлбөрийн данс 0.6 сая төгрөг болж 0.1 сая төгрөгөөр буурсан байна.

#### Аудитын илрүүлэлт:

#### Баруунтуруун сумын Засаг даргын тамгын газар:

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.3 дэх хэсгийг зөрчин 0.3 сая төгрөгийн өглөгийг санхүүгийн тайланд тусгаагүйг залрууллаа.

### 3.5.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 8,529.8 сая төгрөг болж 3,053.0 сая төгрөгөөр буюу 55.7 хувиар өссөн байна

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 2,093.5 сая төгрөгөөр буюу 61.3 хувиар өссөн байна.

Нийт зардал өмнөх оноос 720.0 сая төгрөгөөр буюу 21.7 хувиар өссөн байна.

### 3.5.7 Орлогын данс

Тайлант онд татварын орлого 223.7 сая, татварын бус орлого 2,395.2 сая, тусламж санхүүжилтийн орлого 3,710.0 сая, нийт 6,328.9 сая төгрөгийн үйл ажиллагааны орлого орсон байна.

### 3.5.8 Зардлын данс

Зардлын данстай холбоотой Төсвийн шууд захирагчид 10.7 сая төгрөгийн зөрчил илэрлээ.

#### Аудитын илрүүлэлт:

#### Баруунтуруун сумын Засаг даргын тамгын газар:

- Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.6.2 дахь заалтад "Төсвийн захирагч нь төсвийн асуудлаа өөрийн харьяалагдах дээд шатны төсвийн захирагчаар дамжуулан шийдвэрлүүлдэг байх", 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь заалтад "Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох", Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэгт "Төрийн албан хаагч хуульд зааснаас гадна дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно", 39.1.2 дахь заалтад "Албаны эрх мэдлээ хэтрүүлэх" гэж заасны зөрчин дугаар Баруунтуруун сумын Засаг даргын тамгын газрын даргын 2020 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн Б/10 тушаалаар "Мэдээлэл технологи, үйлчилгээний нэгдсэн төвийн операторын гэрээт ажилтнаар томилж албаны эрх мэдлээ хэтрүүлсэн 5.7 сая төгрөгийн алдаа зөрчилд албан шаардлага өглөө.

20

ХЯЗГААРЛАЛТАЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ

- Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтад "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ыг зөрчин бага үнэтэй түргэн элэгдэх зүйлсийн зардлаас эдийн засгийн ангилал зөрчиж 0.3 сая төгрөгийн 2 гүйлгээ хийсэнд албан шаардлага өглөө.

#### **Баруунтуруун сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал:**

- Баруунтуруун сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга нь эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэргүйгээр өөртөө шийдвэр гарган 1.2 сая төгрөгийн цалин авсанд албан шаардлага өглөө.

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас тогтоол шийдвэргүйгээр цагдаагийн интернэтийн төлбөрт гэж 0.1 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсанд зөрчил арилгуулах албан шаардлага өглөө.

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас 3.4 сая төгрөгийн шатах тослох материалыг ямар үйл ажиллагаанд зарцуулсан нь тодорхойгүй, зарцуулалтын тайлангүй зэрэг үндэслэх анхан шатны баримтгүй зарцуулсанд төлүүлэхээр төлбөрийн акт тогтоолоо.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Баруунтуруун сумын 2021 оны төсвийг сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 2/03 дугаар тогтоолоор 2,892.2 сая төгрөгөөр баталж 2021 оны 08 дугаар сарын 20-ний өдрийн 02 дугаар тогтоолоор тодотгол хийж анх баталсан дүнгээс 71.9 сая төгрөгөөр нэмэгдүүлж 2,964.1 сая төгрөгөөр баталсан байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**


Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөр, 10 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,964.1 сая төгрөгийн төсөв баталснаас 1,977.5 сая төгрөгийг улсын төсвөөс, 844.9 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 41.7 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 99.9 сая төгрөгийг төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,930.7 сая, орон нутгийн төсвөөс 827.3 сая, Эрүүл мэндийн даатгалын сангаас 38.0 сая, төгрөгийн санхүүжилт авч, төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас 103.3 сая, нийт 2,899.4 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 2,757.8 сая төгрөгийг зарцуулж улсын төсөвт 46.8 сая, орон нутгийн төсөвт 15.3 сая, нийт 62.1 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,757.8 сая төгрөг буюу 93.0 хувьтай байгаа нь зардлыг 62.1 сая төгрөгөөр хэмнэж, тусгай зориулалтын шилжүүлгээс 144.2 сая төгрөгийн санхүүжилт дутуу олгосонтой холбоотой байна.

Баруунтуруун сумын ИТХ-ын 2021 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн сумын 2021 оны тодотгосон төсөв батлах тухай 02 дугаар тогтоолд зааснаар Баруунтуруун сумын Засаг дарга тайлант онд 230.0 сая төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 236.6 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 102.8 хувиар биелүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.



бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэж заасныг зөрчин орлогын 17.4 сая төгрөгийн 1 гүйлгээ, зарлагын 59.6 сая төгрөгийн 1 гүйлгээг мэдээлээгүй, орлогын 169.8 сая төгрөгийн 3 гүйлгээ, зарлагын 33.9 сая төгрөгийн 3 гүйлгээг хугацаа хоцроож байршуулсан байна. Иймд Шилэн дансны тухай хуулийг үйл ажиллагаандаа мөрдөж мэдээллийг байршуулан, хугацаа хоцроохгүй байх алдаа зөрчлийг давтан гаргуулахгүй байх албан шаардлага өгсөн.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд зөрчилтэй асуудал байхгүй байна.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөөгүй байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Баруунтуруун сумын Эрүүл мэндийн төвийн хувьд Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих төлбөрт үйлчилгээний орлогын авлага 96.3 сая төгрөг байна. Тухайн авлагын дагуу 2022 оны 1 дүгээр сард санхүүжилтийг олгосон байна. Дараагийн аудитаар тухайн авлагын зарцуулалтыг нарийвчлан шалгах нь зүйтэй гэж үзлээ.

Баруунтуруун сумын Засаг даргын тамгын газрын хувьд Аймгийн Засаг даргын 2021 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн А/43 дугаар захирамжаар сумдын Засаг даргын тамгын газар, багийн бүтэц орон тоог батлахдаа гэрээт ажилтны орон тоог батлаагүй байна. Дараагийн аудитаар энэ асуудлыг анхаарч шалгах нь зүйтэй гэж үзлээ.

Баруунтуруун сумын Хүүхдийн цэцэрлэгийн хувьд тайлант онд улс орныг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас аудитыг цахимаар хийж байгаагаас шалтгаалан байгууллага дээр ажиллаж нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэх, хөрөнгийн биет тооллого хийх гэх мэт хөрөнгийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх нөхцөл байдал хязгаарлагдмал байсныг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

Баруунтуруун сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хувьд дараагийн аудитаар гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зардлыг үнэн зөв зарцуулсан байдлыг харах нь зүйтэй гэж үзлээ.

### 3.12 Харьяа байгууллагуудын аудитын дүнгийн талаар

Баруунтуруун сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 3 тусгай сан, нийт 9 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 6 байгууллагад дүгнэлт гаргаж, 3 санг түүвэрт хамруулсан.

Аудитад хамрагдсан төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа 4 байгууллагын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” санал дүгнэлт, 2 байгууллагад “Хязгаарлалтай” санал дүгнэлт өгсөн байна.

Харьяа байгууллагуудад хийсэн аудитаар нийт 775.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 482.7 сая төгрөгийн 6 алдааг залруулж, 3.4 сая төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 288.1 сая төгрөгийн 5 зөрчилд албан шаардлага өглөө.

Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ЗДТГ	4	71.6	2	65.5			2	6.0		
2	ИТХ	3	4.7			1	3.4	2	1.3		
3	ЕБС	4	667.2	3	385.7			1	280.8		
4	Баруунтуруун сумын Соёл	1	31.5	1	31.5						
<b>Дүн</b>		<b>12</b>	<b>775.0</b>	<b>6</b>	<b>482.7</b>	<b>1</b>	<b>3.4</b>	<b>5</b>	<b>288.1</b>		

#### 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.


/сая төгрөгөөр/

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Баруунтуруун сумын Засаг дарга	0	0.0								
<b>НИЙТ</b>		<b>0</b>	<b>0.0</b>								

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  /М.БАТСУУРЫ/

АУДИТЫН МЕНЕЖЕР  /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР  /Р.АЮУШ/

2022 оны 03 сарын 25-ны өдөр

